

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2018 оны 1-р сарын 3-ны байдлаар


2018 оны 1-р сарын 3-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 0.5 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.3 хувиар буурсан байна.

Махны дундаж үнэ: 2018 оны 1-р сарын 3-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 1.0 хувь, үхрийн ястай махны үнэ 0.5 хувь, үхрийн цул махны үнэ 0.8 хувь, ямааны ястай махны үнэ 3.2 хувиар буурсан бол адууны ястай махны үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад үхрийн ястай махын үнэ 0.1 хувь, үхрийн цул махны үнэ 0.3 хувиар буурч, бусад махны үнэ өөрчлөлтгүй байна.

2018 оны 1-р сарын 3-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 5090 төгрөг, үхрийн /ястай/ мах 6470 төгрөг, үхрийн цул мах 7910 төгрөг, адууны /ястай/ мах 4900 төгрөг, ямааны /ястай/ мах 3435 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ




Гурилын үнэ: 2018 оны 1-р сарын 3-ны байдлаар гурилын үнийг өмнөх сарынхтай болон өмнөх 7 хоногтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2018 оны 1-р сарын 3-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна. (Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2018 оны 1-р сарын 3-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 5.7 хувь, хүрэн манжингийн үнэ 4.2 хувь, луувангийн үнэ 2.9 хувь, байцааны үнэ 8.5 хувь, сонгины үнэ 3.3 хувиар тус бүр буурсан байна.

Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад төмсний үнэ 2.1 хувь, луувангийн үнэ 1.2 хувь, байцааны үнэ 7.4 хувь, сонгины үнэ 3.3 хувиар буурсан бол хүрэн манжингийн үнэ өөрчлөлтгүй байна.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2018 оны 1-р сарын 3-ны байдлаар сүүний үнийг өмнөх сарынхтай харьцуулахад задгай сүүний үнэ 7.6 хувиар өссөн бол бусад сүүний үнэ өөрчлөлтгүй байна. Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй. Цөцгийн тосны үнэ өмнөх сараас 0.4 хувиар өссөн бол өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.